

БАТЛАВ
“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН
ТӨВ” ОНӨТҮГ-ЫН ЗАХИРАЛ




Ч.ХУВЬЗАЯА

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

**“ШИЙТГЭЛИЙН ХУУДСЫГ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭЗЭМШИГЧ,
ӨМЧЛӨГЧДӨД ЦАХИМААР ХҮРГЭХ” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН
ШААРДЛАГА**

№	Ажлын даалгавар	
1	Үндсэн ажлын даалгавар	<ul style="list-style-type: none">• “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын зөрчлийн мэдээллийн санд хандаж замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийн мэдээллийг боловсруулан зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ. Ингэхдээ Төрийн нийтийн мэдээллийн системийн дэмжих системүүдэд бүртгэлтэй гар утасны дугаар руу замын хөдөлгөөний дүрэм зөрчиж торгуулсан тухай мэдээллийг тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигчдэд уг системээр дамжуулан хүргэнэ.• Цахим хүргэлтийг төрийн нийтийн мэдээллийн системийн дэмжих системүүдээр дамжуулах.• Зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч нь цахим зөрчлийн хуудсанд хандахдаа нууцлал хамгаалалтыг бүрэн хангасан байх ба шийтгэлийн хуудсыг татах, төлбөр төлөх боломжтой байна.• Цахим хүргэлтийн шийтгэлийн хуудас татаж авсан, танилцсан төлбөр төлсөн зэрэг тайлан мэдээг гаргадаг байна.• Цахим хүргэлтийн үйлчилгээг гэрээ байгуулагдсан өдрөөс эхлүүлнэ.
2	Нэмэлт шаардлага	<ul style="list-style-type: none">• Зөрчил гаргасан даруйд тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийн төрийн нийтийн мэдээллийн системийн дэмжих системүүдэд бүртгэлтэй гар утасны дугаар луу санамж, анхааруулга мессеж хүргэх боломжтой байх.• Төрийн нийтийн мэдээллийн систем дээр бүртгэлгүй, эсвэл суурин утас ашигладаг бол шийтгэлийн хуудсыг үзэх, хэвлэж авах боломжийг бүрдүүлсэн байх Шийтгэлийн хуудсыг илгээгдсэн, танилцсан, татаж авсан, төлбөр төлсөн зэргээр бүртгэл хөтөлдөг байх.• “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын зөрчлийн мэдээллийн сангаас төрөл бүрээр тайлан гаргах боломжтой байх /Цахим шийтгэлийн хуудсыг хүлээн авсан болон аваагүй тоо, нийт явсан шийтгэлийн хуудасны тоо,

		<p>төлбөр төлсөн, төлөгдсөн торгуулийн мөнгөн дүн өдөр, сар, улирлаар, гэх мэт огноогоор шүүж харуулах/дөтгөөний</p> <ul style="list-style-type: none"> • ЗХУТ-н мэдээллийн сангаас татвар болон оношилгоонд ороогүй замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн регистрийн дугаар болон бусад мэдээллийг татан авч боловсруулах холбоосыг үүсгэх Регистрийн дугаараар нь “E-MONGOLIA” төрийн үйлчилгээний цахим системийн “Дан” танилт нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэлтэй гар утасны дугаар луу анхааруулах мэдээллийг мессежээр илгээх. • Холбогдох тайлан мэдээ, үр дүнгийн хамт захиалагчид ирүүлэх, бүртгэл дэлгэрэнгүй байх. • Илгээсэн мессежийг хүлээн аваагүй, “Дан” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем дээр бүртгэлгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийн мэдээллийг “Зам тээврийн яам”-нд бүртгэлтэй гар утас руу багц мессеж үйлчилгээгээр илгээх. • Аж ахуй нэгж байгууллагуудын замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тээврийн хэрэгслийн шийтгэлийн хуудсыг ангилж хэвлэх, мөн и-майлаар шийтгэлийн хуудсыг хэвлэх боломжтой байх. • Цахим шийтгэлийн хуудаснаас бүх төрлийн цахим төлбөрийн хэрэгсэл ашиглан торгуулийн төлбөр төлөх боломжтой байх. • Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлд тусгасны дагуу зөрчил гаргасан жолооч, хуулийн этгээд торгуулийг хугацаандаа /15 хоногт/ төлбөл торгуулийн хэмжээг 50 хувиар хөнгөлж төлөх, жолооч, хуулийн этгээд торгуулиа хуульд заасан хугацаа буюу 15 хоногоос хэтрүүлсэн тохиолдолд торгуулийн хэмжээг 50 хувь хүртэл нэмэгдүүлж төлөх боломжийг бүрдүүлсэн байна. • Шийтгэлийн хуудсыг архивлах, мэдээллийг хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна. • Шаардлагатай жагсаалтан болон тоон тайланг хүссэн огноогоор гаргах нөхцөл бүрдүүлсэн байна.
--	--	--



ХЯНАСАН:

ЗӨРЧИЛ БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Ш.ГАНТӨМӨР

БОЛОВСРУУЛСАН:

ЗӨРЧИЛ БҮРТГЭЛ,
СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН

 А.ОТГОН-ӨЛЗИЙ